



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.17, 25.6 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ыг нэгдүгээр, “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ыг хоёрдугаар, “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргах өргөдлийн маяг”-ыг гуравдугаар, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг бүртгэх дэвтрийн загвар”-ыг дөрөвдүгээр, “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг бүрдүүлэлтийн тайлангийн маягт, багц цаг бүрдүүлсэн хэлбэрийг бүртгэх код”-ыг тавдугаар, “Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар”-ыг зургаадугаар, “Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар”-ыг долоодугаар, “Гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулгын маягт”-ыг наймдугаар, “Зөвшөөрлийн шалгалтын комиссын гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлгийн маягт”-ыг есдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Г.Ганчимэг/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 68 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080324

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
98 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, НӨХӨН ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (цаашид “зөвшөөрөл” гэх)-тэй холбоотой үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хууль, энэхүү журам, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

1.2. Зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүрэг бүхий орон тооны бус Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) ажиллах ба зөвлөлийн бүрэлдэхүүнийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн асуудал хариуцсан нэгж (цаашид “ажлын алба” гэх) нь зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгохтой холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.4. Энэхүү журам нь хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллаж байгаа болон анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж төгсөж, дээрхи чиглэлээр ажиллах гэж буй эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна.

1.5. Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3-д заасны дагуу 2 ба 5 жилийн хугацаагаар олгоно. Зөвшөөрөл олгосныг нотлох баримт нь зөвшөөрлийн гэрчилгээ байна.


1.6. Эмнэлгийн мэргэжилтний төрөлжсөн мэргэшлээрээ ажиллах баталгаа нь тухайн мэргэшлийн сургалтанд суралцсаныг нотлох баримт бичиг байна.

1.7. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1–д заасан зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн нь эхний жил өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт, хоёр дах жил өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд их эмчээр ажиллана.

Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагаа

2.1 Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах;

- 
- 2.1.2 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд бодлогын зөвлөгөө өгөх;
- 2.1.3 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаарх санал, зөвлөмжийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд уламжлах;
- 2.1.4 Эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавих;
- 2.1.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг Монгол Улсад ажиллуулах мэргэжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулах;
- 2.1.6 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох эсэх талаар хэлэлцэн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал хүргүүлж, шийдвэрлүүлэх;
- 2.1.7 Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан байгууллагуудын лавлагааг үндэслэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж, шийдвэрлүүлэх.

2.2 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

2.3 Зөвлөл нь сард 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн даргын санаачлагаар ээлжит бус хурал зарлан хуралдуулж болно.

2.4 Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын төлөвлөгөө, хурлаар хэлэлцэх асуудлыг зөвлөлийн даргад танилцуулж батлуулан, зөвлөлийн гишүүдэд хурал болохоос ажлын 3 хоногийн өмнө хүргүүлсэн байна.

2.5 Зөвлөлийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай бүрэн танилцаж, саналаа бэлтгэж ирнэ. Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан байгууллагуудын төлөөлөл гадаадын эмнэлгийн мэргэжилтний асуудлыг хэлэлцэхэд оролцоно.


2.6 Зөвлөлийн дарга хурлын дэгийг батална. Шаардлагатай үед зөвлөлийн даргын шийдвэрээр төлөвлөгөөнд тусгагдаагүй асуудлыг нэмэлтээр хэлэлцэж болно.

2.7 Зөвлөлийн гишүүдийн 2/3 нь ирсэн тохиолдолд хурал хүчин төгөлдөр байна. Зөвлөлийн гишүүн нь хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй тухайгаа хурал болохоос 1-ээс доошгүй хоногийн өмнө зөвлөлийн даргад мэдэгдэж, зөвлөлийн дарга зөвшөөрвөл саналаа цахим болон цаасан хэлбэрээр ирүүлж болно. Энэ тохиолдолд саналыг хүчинтэйд тооцно.

2.8 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хурлаар хэлэлцсэн асуудлын тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн дарга болон гишүүдээр гарын үсэг зуруулна.

2.9 Зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолын төслийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан бэлтгэж, зөвлөлийн даргад танилцуулан зөвлөлийн хурлаас хойш ажлын 2 хоногт багтаан баталгаажуулж, ажлын албанд хүргүүлнэ.


2.10 Зөвлөлийн тогтоолыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн төслийг ажлын алба хариуцан бэлтгэж, зөвлөлд хүргүүлнэ. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталгаажсан шийдвэрийг ажлын албанд хүргүүлнэ.



Гурав. Ажлын албаны чиг үүрэг

3.1 Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 3.1.1 Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгохтой холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 3.1.2 Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг боловсруулж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжээр хянуулсны үндсэн дээр зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;
- 3.1.3 Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах;
- 3.1.4 Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилын санг бүрдүүлэх, гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилын санг монгол, англи хэл дээр үүсгэх;
- 3.1.5 Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилын сангийн 50-иас доошгүй хувийг жил бүр шинэчлэн, баяжилтыг тогтмол хийж, нууцлалыг бүрэн хариуцан ажиллах;
- 3.1.6 Дотоодын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох шийдвэрийн төслийг зөвшөөрлийн шалгалт авснаас хойш ажлын 7 хоногт, зөвшөөрөл нөхөн олгох тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн хүсэлт гаргаснаас хойш ажлын 5 хоногт, зөвшөөрөл хүчингүй болгох тохиолдолд холбогдох шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт, багц цаг биелүүлсэн эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох шийдвэрийн төсөл болон багц цаг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний нэрсийг жил бүрийн 12 дугаар сарын 20-нд багтаан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжид тус тус ирүүлэх;
- 3.1.7 Зөвлөлөөс 6 сар ба түүнээс доош хугацаагаар ажиллахыг дэмжсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох шийдвэрийн төслийг хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 1 хоногт, зөвшөөрлийн шалгалтанд тэнцсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох шийдвэрийн төслийг шалгалт авснаас хойш ажлын 2 хоногт, зөвшөөрөл хүчингүй болгох тохиолдолд холбогдох шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжид тус тус ирүүлэх;

- 
- 3.1.8 Зөвлөлийн шийдвэр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг холбогдох байгууллагуудад тухай бүр шуурхай хүргүүлж, танилцуулах;
- 3.1.9 Багц цагийн бүрдэлт, зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх, гарын авлагаар хангах, сургалт зохион байгуулах;
- 3.1.10 Зөвшөөрлийн цахим мэдээний санг дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн тус бүрээр бүрдүүлж, эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн талаархи мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулах;
- 3.1.11 Зөвшөөрөл олгосон, нөхөн олгосон, хүчингүй болгосон тохиолдолд цахим мэдээний санд тухай бүр тусгах;
- 3.1.12 Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар судалгаа хийж, судалгааны үр дүнг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, судалгааны мэдээллийн сан үүсгэх;
- 3.1.13 Шаардлагатай тохиолдолд гадаад орны холбогдох байгууллагатай харилцаж, зөвшөөрөл хүссэн гадаадын эмнэлгийн мэргэжилтний талаар тодорхойлолт, тодруулга авах;
- 3.1.14 Зөвшөөрөл олгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаанд явцын хяналт тавих;
- 3.1.15 Шаардлагатай тохиолдолд гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой холбоотой хяналт-үнэлгээг холбогдох байгууллагатай хамтран хийх;
- 3.1.16 Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан байгууллага, хуулийн байгууллага зэрэг холбогдох талуудтай хамтран ажиллаж, мэдээлэл харилцан солилцох;
- 3.1.17 Дотоод, гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн талаарх статистик мэдээ тайлан, дүн шинжилгээ бүхий тайланг тус тус нэгтгэн гаргаж, жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх.
- 3.2 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ажлын албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

Дөрөв. Зөвшөөрлийн шалгалт

4.1 Зөвшөөрлийн шалгалтанд тэгш, хараат бус, ил тод, үл ялгаварлах зарчмыг баримтална.

4.2 Дараах нөхцөлд эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалтанд орох хүсэлт гаргана:

4.2.1 Хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж төгсөгчид;

4.2.2 Энэхүү журмын 5.6.1, 5.6.2-д заасны дагуу зөвшөөрлийг хүчингүй болгосон хугацаа нь дуусч, зөвшөөрөл олгох эрх үүссэн, 5.6.3, 5.6.4-д заасан эмнэлгийн мэргэжилтэн.

4.3 Анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий дотоодын их, дээд сургууль, коллеж нь жил бүрийн төгсөлтийн шалгалт дууссанаас хойш ажлын 20 хоногт багтаан төгсөгчдийн нэрсийг баталгаажуулсан жагсаалтыг ажлын албанд албан тоотгоор ирүүлнэ.

4.4 Энэхүү журмын 4.2-т заасан эмнэлгийн мэргэжилтэн нь зөвшөөрлийн шалгалтанд орох хүсэлтийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хаягаар эсвэл цаасан хэлбэрээр гаргана.

4.5 Зөвшөөрлийн шалгалтыг цахим эсвэл цаасан хэлбэрээр авна. Нийслэлд цахим хэлбэрээр 7 хоног бүр, цаасан хэлбэрээр сар тутамд, орон нутагт хагас жилд нэг удаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга/захирлын тушаалаар томилсон шалгалтын комисс (цаашид "комисс "гэх) авна.

4.6 Комиссын гишүүн комисст ажиллахыг зөвшөөрсөн тухайгаа энэхүү тушаалын есдүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, шалгалт эхлэхээс 2-оос доошгүй хоногийн өмнө ажлын албанд хүлээлгэн өгнө.

4.7 Зөвшөөрлийн шалгалтыг олон хувилбарт сорилоор авна.

4.8 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл нь энэхүү журмын хүрээнд холбогдох чиглэлээр зөвшөөрлийн шалгалтын сорилыг боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгнө. Ажлын алба нь сорил, сорилын түлхүүрийг нэгдсэн сангаас тухай бүр бэлтгэж, шалгалтыг авна.

4.9 Зөвшөөрлийн шалгалтын сорил нь дотоодын ба гадаадын эмнэлгийн мэргэжилтний гэсэн 2 төрөлтэй байна.

4.10 Энэхүү журмын 4.2.1-д заасан хүний их эмч болон ерөнхий мэргэжлийн их эмчийн зөвшөөрлийн шалгалтын сорилын 65 хувь нь ерөнхий мэргэжлийн, 5 хувь нь төрөлжсөн мэргэшлийн анагаах ухааны, 20 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 5 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуултууд байна.

4.11 Энэхүү журмын 4.2.1-д заасан уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагчийн зөвшөөрлийн шалгалтын сорилын 70 хувь нь тухайн мэргэжлийн, 20 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 5 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуултууд байна.

4.12 Энэхүү журмын 4.10-д зааснаас бусад хүний их эмчийн зөвшөөрлийн шалгалтын сорилын 75 хувь нь үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн анагаах ухааны (төрөлжсөн мэргэшлээр суралцсан бол 20 хувь нь тухайн чиглэлээр), 10 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 10 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ба био-анагаахын ёс зүйн асуултууд байна.

4.13 Энэхүү журмын 4.11-д зааснаас бусад уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагчийн зөвшөөрлийн шалгалтын сорилын 75 хувь нь тухайн мэргэжлийн (төрөлжсөн мэргэшлээр суралцсан бол 20 хувь нь тухайн чиглэлээр), 10 хувь нь нийгмийн эрүүл мэндийн, 5 хувь нь эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн, 10 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ба био-анагаахын ёс зүйн асуултууд байна.

4.14 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтын сорилыг монгол, англи хэлээр бүрдүүлэх ба сорилын 80 хувь нь тухайн төрөлжсөн мэргэшлийн, 10 хувь нь био-анагаахын ёс зүйн, 5 хувь нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн, 5 хувь нь Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн талаарх асуултууд байна.

4.15 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн сорилын сангийн англи хувилбарын орчуулгыг “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 3.4-д заасан шаардлагыг хангасан орчуулагчтай гэрээ байгуулан хийлгэнэ.

4.16 Зөвшөөрлийн шалгалтанд 70 буюу түүнээс дээш оноо авсан эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл авах эрх үүснэ.

4.17 Ажлын алба нь нийслэлд зохион байгуулсан шалгалтын дүнг шалгалт авснаас хойш ажлын 3 хоногт, орон нутагт зохион байгуулсан шалгалтын дүнг шалгалт авснаас хойш ажлын 5 хоногт багтаан тус тус нэгтгэж, тухайн хугацаанд багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулна.

4.18 Зөвшөөрлийн шалгалтанд тэнцэж зөвшөөрөл авах эрх үүссэн, зөвшөөрөл нөхөн олгох эмнэлгийн мэргэжилтэн дараах баримт бичгийг ажлын албанд бүрдүүлж өгнө. Үүнд:

- 4.18.1 Зөвшөөрөл хүссэн өргөдөл (энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу);
- 4.18.2 Боловсролын дипломын хуулбар (зөвшөөрлийн шалгалт анх удаа өгсөн эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна);
- 4.18.3 4х6 хэмжээтэй зураг 2 хувь;
- 4.18.4 Шалгалт болон тэмдэгтийн хураамж төлсөн баримт (зөвшөөрөл нөхөн олгох эмнэлгийн мэргэжилтэнд шалгалтын хураамж төлсөн баримт хамаарахгүй);
- 4.18.5 Зөвшөөрлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлуулсан баримт (зөвшөөрөл нөхөн олгох эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна).

4.19 Зөвшөөрлийн шалгалттай холбоотой гомдлыг комисст гаргана. Комисс гомдлыг судалж, хуулийн хугацаанд шийдвэрлэнэ.

4.20 Гомдол гаргагч нь комиссын шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд ажлын албанд хүсэлтээ тавьж, шийдвэрлүүлнэ.

Тав. Зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох

5.1 Энэхүү журмын 3.1.6, 5.4, 6.9-д заасан хугацаанд ирүүлсэн шийдвэрийн төслийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр гарна.

5.2 Энэхүү журмын 5.1-т заасан шийдвэрийн төслийн үнэн зөв байдлыг ажлын алба бүрэн хариуцах ба эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжийн мэргэжилтэн, дарга хянаж, зөвлөлийн дарга зөвшөөрснөөр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

5.3 Эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох тухай шийдвэр, зөвшөөрлийн гэрчилгээтэй холбоотой алдаа гарсан тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга/захирал, ажлын албаны холбогдох албан тушаалтнуудад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно. Алдаа гаргасан албан тушаалтнаар тэмдэгтийн хураамжийг төлүүлнэ.

5.4 Ажлын алба нь залруулга хийх тухай шийдвэрийн төслийг ажлын 3 хоногт багтаан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.5 Ажлын алба нь энэхүү журмын 4.18-д заасан баримт бичгийг хянаж, зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох үндэслэлтэй (зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусаагүй, өмнөх оны багц цаг биелсэн) гэж үзвэл үрэгдүүлсэн гэрчилгээний хүчинтэй хугацаагаар нөхөн олгох ба энэ тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалтанд орох шаардлагагүй.

5.6 Зөвшөөрлийг дараах тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хүчингүй болгох ба ажлын алба нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудас, эрүүл мэндийн ажилтны мэдээний нэгдсэн санд байршуулан нийтэд мэдээлнэ:

5.6.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 26.3-т заасны дагуу;

5.6.2 Шүүхийн шийдвэрийн дагуу;


5.6.3 Зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд багц цаг биелүүлээгүй бөгөөд зөвшөөрлийн шалгалтанд ороогүй буюу тэнцээгүй;

5.6.4 Нэг жилээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй.

Зургаа. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цагийн биелэлт, бүртгэл

6.1 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын агуулгын багтаамжийг багц цагаар тодорхойлно. Уг сургалтын 1 багц цаг нь лекцийн 12, дадлагын 24 цагтай тус тус дүйцнэ.

6.2 Зөвшөөрөл бүхий хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эм зүйч жил тутам 6 багц цаг, хүний бага эмч, эх баригч, сувилагч, эм найруулагч жил тутам 3 багц цагийн багтаамж бүхий сургалтанд хамрагдана.



6.3 Аймгийн төвөөс 100 ба түүнээс дээш км-т алслагдсан нутагт ажиллаж байгаа бол их эмч, эм зүйч жил тутам 4 багц цаг, сувилагч, эм найруулагч, бага эмч, эх баригч жил тутам 2 багц цагийг бүрдүүлнэ.

6.4 Зөвшөөрлийн хугацаа дуусч буй, эрүүл мэндийн байгууллагад эзэмшсэн мэргэжлээрээ тасралтгүй 25 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтэн болон мэргэжлээрээ ажиллаж буй Монгол Улсын Ардын эмч, Хүний гавьяат эмч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан жил тутамд 1,5 багц цагаас доошгүй сургалтанд хамрагдана.

6.5 Эмнэлгийн мэргэжилтний жил тутам биелүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр байна.

6.6 Энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг бүртгэх дэвтэр” (цаашид “багц цагийн дэвтэр” гэх) мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй эмнэлгийн мэргэжилтэн бүрт байна.

6.7 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цагийн биелэлтийг өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч; сум, тосгоны эрүүл мэндийн төв болон сум дундын эмнэлгийн эрхлэгч; Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.4-15.1.10-д заасан байгууллага болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан албан тушаалтан (хэрэв байхгүй бол дарга/захирал) хянан үзэж, багц цагийн дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулан, энэхүү тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу байгууллагын тамга дарж, багц цаг биелүүлсэн болон биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалтыг харьяалах аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар (цаашид “аймаг, нийслэлийн ЭМГ” гэх)-т жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлнэ.

6.8 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн энэхүү журмын 6.7-т заасан жагсаалтыг нэгтгэн, ажлын албанд жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор албан тоотоор ирүүлнэ. Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.11, 15.1.12-д заасан байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэн багц цаг биелүүлсэн болон биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалтыг ажлын албанд жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлнэ.

6.9 Ажлын алба нь ирүүлсэн тайланг хянаж, энэхүү журмын 6.2, 6.3, 6.4-т заасан багц цаг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг тухайн оны эцэст хүчингүйд тооцон, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

6.10 Ажлын алба нь энэхүү журмын 6.9-д заасан эмнэлгийн мэргэжилтний нэрсийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан, зөвшөөрлийн шалгалтанд орохыг шаардсан мэдэгдлийг харьяалах аймаг, нийслэлийн ЭМГ, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор албан тоотоор хүргүүлнэ.

6.11 Багц цаг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтэн зөвшөөрлийн шалгалт өгнө. Зөвшөөрлийн шалгалтанд тэнцээгүй буюу зөвшөөрөл нь хүчингүй болсон эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

6.12 Багц цаг биелүүлсэн эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл нь зөвшөөрлийн гэрчилгээнд заасан хугацаанд хүчинтэйд тооцогдоно.

6.13 Багц цагаа тасралтгүй биелүүлж ажилласан, 5 жилийн хугацаатайгаар зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн хугацаа дуусахад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Эрүүл мэндийн тухай хуульд заасан хугацаагаар зөвшөөрлийг олгоно.

6.14 Багц цагийн бүрдүүлэлт:

№	Багц цагийг бүрдүүлэх хэлбэр	Тооцох багц цаг	Баталгаажуулах баримт
А. Албан сургалт			
1.	Үндсэн мэргэшлийн сургалтанд суралцсан жил тутамд	6	Дүнгийн дэвтэр, төгссөн мэргэжлийн үнэмлэхний хуулбар
2.	Мэргэжил олгох сургалт	эмнэлгийн дээд мэргэжилтэн	Үнэмлэхний хуулбар
		сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	
3.	Мэргэжил дээшлүүлэх сургалт	эмнэлгийн дээд мэргэжилтэн	Үнэмлэхний хуулбар
		сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	
4.	Анагаах ухааны магистрын сургалтанд суралцсан жил тутамд	6	Дүнгийн дэвтэр, төгссөн мэргэжлийн үнэмлэхний хуулбар
5.	Анагаах ухааны докторын сургалтанд суралцсан жил тутамд	6	
Б. Албан бус сургалт			
1.	Мэргэжлийн чиглэлээр семинарт оролцох 1.1 Олон улсын хэмжээнд 1.2 Улсын хэмжээнд 1.3 Орон нутгийн хэмжээнд	1	Албан шийдвэр, хөтөлбөр, урилга
		0,5	
		0,25	
2.	Мэргэжлийн төрөлжсөн зөвлөгөөн, хуралд илтгэл тавих 2.1 Олон улсын хэмжээнд 2.2 Улсын хэмжээнд 2.3 Орон нутгийн хэмжээнд	1	Илтгэлийн хураангуй
		0,5	
		0,25	
3.	Эмгэг судлалын конференцид оролцох	0,1	Ирцийн бүртгэл
4.	Мэргэжлийн чиглэлээр зайны сургалтанд суралцах	Зөвшөөрөгдсөн багц цаг	Хөтөлбөр, сэдэв, сертификат
5.	Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны болон сэдэвчилсэн сургалтанд суралцах	Зөвшөөрөгдсөн багц цаг	Батлагдсан сургалтын сэдэв, гэрчилгээний хуулбар

6.	Мэргэжлийн зэрэг хамгаалах	эмнэлгийн дээд мэргэжилтэн	6	Үнэмлэхний хуулбар
		сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн	3	
В. Судалгаа шинжилгээний ажил, бүтээл, практикт нэвтрүүлсэн шинэ санаачлага				
1.	Илтгэл тавих			Хурлын илтгэлийн хураангуйн нэр бүхий хуудасны хуулбар
	1.1 Байгууллагын хэмжээнд		1	
	1.2 Их, дээд сургуулийн хэмжээнд		2	
	1.3 Улс, олон улсын хэмжээнд		3	
2.	Оношилгоо, эмчилгээний стандарт боловсруулахад оролцох		Стандарт тутамд 3	Батлагдсан стандартын хуулбар
3.	Судалгааны ажил удирдах		6	Судалгааны ажлын тайлан
4.	Судалгааны багт орж ажиллах		3	Судалгааны ажлын тайлан
5.	Төсөл, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах		1 х.х ¹ тутамд 0,5	Батлагдсан төсөл, хөтөлбөрийн баримт бичиг
6.	Мэргэжлийн зөвлөмж боловсруулж, хэвлүүлэх		Зөвлөмж тутамд - 1	Хэвлүүлсэн сэтгүүлийн хувь
7.	Гарын авлага, аргачлал боловсруулж, хэвлүүлэх		Нэг бүр - 2	Хэвлүүлсэн сэтгүүлийн хувь
8.	Мэргэжлийн ном туурвих		1 х.х тутам - 1 8 х.х дээш - 6	Зохиогчийн нэр бүхий номын нүүрний хуулбар
9.	Мэргэжлийн ном туурвихад оролцох, шүүмж, дүгнэлт гаргах, хянах		1 х.х тутам - 0,5 8 х.х дээш - 3	Зохиогчийн нэр бүхий номын нүүрний хуулбар
10.	Мэргэжлийн ном орчуулах		1 х.х тутам - 0,25 8 х.х дээш - 3	Орчуулсан хүний нэр бүхий номын нүүрний хуулбар
11.	Мэргэжлийн ном орчуулахад хамтрах		1 х.х тутам - 0,1 8 х.х дээш - 1,5	Орчуулсан хүний нэр бүхий номын нүүрний хуулбар
12.	Шинэ бүтээл, тэргүүн туршлага гаргаж, баталгаажуулсан байх		6	Тухайн хүний нэр бүхий зохиогчийн эрхийн гэрчилгээний хуулбар
13.	Мэргэжлийн сургалтанд хичээл заах		6 цагийн лекц тутамд-1, 12 цагийн дадлага тутамд -1	Сургалтын батлагдсан хөтөлбөр

¹ х.х – хэвлэлийн хуудас

14.	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийх	Телевизийн нэвтрүүлгийн 30 минут тутамд 0,1	Сургалт явуулсан тухай бичлэгийн хуулбар
		Сонины 1/8 нүүр тутамд 0,1	Сонины хуулбар
15.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ арга технологи нэвтрүүлэх	Шинээр нэвтрүүлсэн шинэ арга технологи 0,5	Тухайн байгууллагын удирдлагын зөвлөлийн тодорхойлолт, хагас бүтэн жилийн тайланд тусгагдсан байх, мэдээний сангийн бүртгэлд давхцаагүй байх

6.15 Багц цагийн бүрдүүлэлт, оноо тооцох аргачлалын 14, 15-д заасан хэлбэрээр тухайн жилийн багц цагийн 25 хүртэлх хувийг бүрдүүлэхийг зөвшөөрнө.

6.16 Эмнэлгийн мэргэжилтний тухайн жилд биелүүлсэн багц цаг нь энэхүү журмын 6.2, 6.3, 6.4-т зааснаас илүү гарсан тохиолдолд дараагийн жилд шилжүүлэн тооцохгүй.

6.17 Эмнэлгийн мэргэжилтэн нь гадаад оронд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтанд суралцсан тохиолдолд багц цагийг дотоодын сургалттай адилтган үзэж, гэрчилгээ, үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичгийг үндэслэн тооцно.

6.18 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт эрхлэх зөвшөөрөлтэй байгууллагын зохион байгуулсан сургалтаар олгогдсон багц цагийг хүчинтэйд тооцно.

6.19 Эрүүл мэндийн байгууллага бүр эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтанд хамруулах төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ.

Долоо. Мэдээний сан

7.1 Ажлын алба нь эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн мэдээний санг дотоодын эмнэлгийн мэргэжилтэн, гадаадын эмнэлгийн мэргэжилтэн, зөвшөөрөл хүчингүй болсон мэргэжилтэн гэсэн 3 төрлөөр бүрдүүлэн ажиллана. Түүнчлэн эмнэлгийн мэргэжилтний багц цагийн бүрдүүлэлтийн мэдээний санд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлсэн шинэ арга, технологийг тогтмол бүртгэнэ.

7.2 Ажлын алба нь зөвшөөрлийн мэдээний сангийн баяжилтыг сар бүрийн 5-ны дотор хийсэн байна.

7.3 Ажлын алба нь зөвшөөрлийн мэдээний санд үндэслэн улирал, жилийн эцэст тайлан гаргаж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж болон Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын

хороонд албан тоотор хүргүүлэн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулна.

Найм. Хяналт, хариуцлага


8.1 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь ажлын албаны үйл ажиллагаанд дотоодын хяналтыг тогтмол хийж, үр дүнг тооцон шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.2 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудит хийнэ.

8.3 Энэхүү журмын 8.2-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын дүнг зөвлөлийн хурлаар тухай бүр хэлэлцүүлж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын чиглэл, хариуцлагын арга хэмжээний саналыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга/захиралд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

8.4 Энэхүү журмыг зөрчсөн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
9.8 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТЭНД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эмчлэх, сувилах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (цаашид “зөвшөөрөл” гэх) олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд хамаарна.

1.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Монгол Улсын анагаах ухааны тэргүүлэх чиглэлийн дагуу гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь зөвхөн төрөлжсөн мэргэшлийн үйл ажиллагааг эрхэлнэ.

1.4. Монгол Улсад эмнэлзүйн стандарт, удирдамж нь батлагдсан мэргэжлийн чиглэл болон өндөр хөгжилтэй орны анагаах ухааны салбарт нэвтэрч, үр дүн нь нотлогдсон эмчилгээ, оношлогоо, сувилахуйн чиглэлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн ажиллахыг дэмжинэ.

1.5. Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд “эм барих”, “эх барих” чиглэлээр зөвшөөрөл олгохгүй бөгөөд гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь эм, эмнэлгийн хэрэгсэл авчран, үйл ажиллагаа явуулах тохиолдолд эм, эмнэлгийн хэрэгслийн зөвшөөрлийн асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Импортын лиценз олгох журам”-ын дагуу зохицуулна.


1.6. “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”-ын 1.2, 1.3 дах заалт, 2, 3, 4, 5, 8 дугаар бүлгийн заалтууд энэхүү журамд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Хоёр. Зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

2.1 Дараах шалгуурыг хангасан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргана:

- 2.1.1 Анагаах ухаан, сувилахуйн бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- 2.1.2 Зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичигтэй байх;
- 2.1.3 Төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр суралцсаныг нотлох хүчин төгөлдөр баримт бичигтэй байх;

- 2.1.4 Тухайн төрөлжсөн мэргэшлээрээ 5 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;
- 2.1.5 Эрүүл мэндийн байгууллагын байнгын ажлын байранд ажиллах бол Монгол Улсын хууль тогтоомжид заасан тэтгэврийн насны хязгаарт байх.



2.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж буй Монголын талын байгууллага нь (цаашид “байгууллага” гэх) гадаадын эмнэлгийн мэргэжилтэнг Монгол Улсад ирэхээс ажлын 20-иос доошгүй хоногийн өмнө дараах баримт бичгийг ажлын албанд ирүүлнэ. Үүнд:

- 2.2.1 Тухайн төрөлжсөн мэргэшлээр гадаадын эмнэлгийн мэргэжилтэн зайлшгүй ажиллуулах хэрэгцээг тодорхойлсон албан бичиг;
- 2.2.2 Байгууллагын даргын баталсан “Гүйцэтгэх ажил үйлчилгээний төлөвлөгөө”;
- 2.2.3 Байгууллагын эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн баталгаат хуулбар;
- 2.2.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулга (энэхүү тушаалын наймдугаар хавсралтаар баталсан маягтын дагуу);
- 2.2.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний паспорт, түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.6 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрөл буюу түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.7 Анагаах ухааны чиглэлээр боловсрол эзэмшсэнийг нотлох үнэмлэх, диплом, түүнтэй адилтгах хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.8 Төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр суралцсаныг нотлох хүчин төгөлдөр баримт бичгийн хуулбар, баталгаат монгол орчуулгын хамт;
- 2.2.9 Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагуудын лавлагаа;
- 2.2.10 Энэхүү журмын 3.4-т заасан шалгуурыг хангасныг нотлох орчуулагчийн баримт бичгийн баталгаат хуулбар.

2.3 Энэхүү журмын 2.2.6-2.2.8-д заасан баримт бичгүүдийг Монгол Улсын эрүүл мэндийн салбарт хэрэглэгддэг албан ёсны нэршлээр орчуулсан байна.

2.4 Ажлын алба нь энэхүү журмын 2.2-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан шалгаж, шаардлага хангасан баримт бичгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжид хүргүүлэн хянуулж, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлүүлнэ.

2.5 Шаардлага хангасан гадаадын эмнэлгийн мэргэжилтний асуудлыг зөвлөлийн хурлаар ажлын алба хариуцан хэлэлцүүлнэ.

2.6 Зөвлөл нь энэхүү журмын 1.3-т заасныг баримтлан гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгохыг дэмжих эсэх талаар шийдвэр гаргана.

2.7 Зөвлөлөөс гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Монгол Улсад 6 сар ба түүнээс доош хугацаагаар зөвшөөрөл олгохыг дэмжсэн тохиолдолд зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулж олгоно.

2.8 Энэхүү журмын 2.7-д заасан хугацаагаар ажиллах зөвшөөрөл авсан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь Монгол Улсад үргэлжлүүлэн ажиллах тохиолдолд байгууллага нь зөвшөөрлийн хугацаа дуусахаас ажлын 20-иос доошгүй хоногийн өмнө гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг үргэлжлүүлэн ажиллуулах зайлшгүй хэрэгцээг тодорхойлсон албан бичгийг ажлын тайлан, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан байгууллагуудын лавлагааны хамт ажлын албанд хүргүүлнэ.

2.9 Энэхүү журмын 2.8-д заасан гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь ажлын албанаас зарласан хугацаанд зөвшөөрлийн шалгалтанд орж тэнцсэн тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгоно.

2.10 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь зөвшөөрлийн шалгалтыг монгол, англи хэлний аль нэгийг сонгон өгч болно.

2.11 Ажлын алба нь гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн шалгалтанд орох хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан цаасан хэлбэрээр авч, шалгалтын дүнг шалгалт авсан өдрөөс хойш ажлын 2 хоногт багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулна.

2.12 Ажлын алба нь дор дурдсан гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэрсийн жагсаалт бүхий шийдвэрийн төслийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжээр хянуулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна. Үүнд:

2.12.1 Зөвлөлөөс 6 сар ба түүнээс доош хугацаагаар ажиллахыг дэмжсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэн;

2.12.2 Шалгалтанд орж тэнцсэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэн.

2.13 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрөл олгох тухай шийдвэрийн төслийг баталгаажуулахад дараах баримт бичгийг хавсаргасан байна. Үүнд:

2.13.1 Зөвлөлийн шийдвэр;

2.13.2 Шалгалтын комиссын дүгнэлт.

2.14 Энэхүү журмын 2.2, 2.8-д заасан баримт бичгийг дутуу эсвэл хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрлийг олгохгүй.

2.15 Монгол Улсад тохиолдсон байгалийн гамшиг, осол, нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлт болон бусад онцгой тохиолдлын үед Монгол Улсын Засгийн газрын хүсэлтээр ирж ажиллах гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр ажлын 1 хоногт багтаан олгож болно.

2.16 Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн дагуу төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг иргэдэд үнэ төлбөргүй үзүүлэх зорилгоор тус улсад богино хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд Зөвлөлөөр хэлэлцүүлэхгүйгээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжээр баримт бичиг, шийдвэрийн төслийг хянуулан, зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр ажлын 3 хоногт багтаан олгож болно.

2.17 Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй байгуулсан урт хугацаагаар хамтран ажиллах гэрээний дагуу өмнөх жил ирж ажиллахдаа ямар нэг зөрчил гаргаагүй гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дахин ирж буй тохиолдолд асуудлыг Зөвлөлөөр хэлэлцүүлэхгүйгээр эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжээр баримт бичиг, шийдвэрийн төслийг хянуулан, зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр ажлын 5 хоногт багтаан олгож болно.

2.18 Энэхүү журмын 2.12, 2.15, 2.16, 2.17-д заасан шийдвэрийн төслийн үндэслэл, үнэн зөв байдлыг ажлын алба бүрэн хариуцна.

Гурав. Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг урьж буй байгууллагын эрх, хүлээх үүрэг

3.1 Байгууллага нь дараах эрхтэй:

- 3.1.1 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн асуудлаар хүсэлт гаргаж, журамд заасан хугацаанд шийдвэрлүүлэх;
- 3.1.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд цалин олгох бол цалин, хөлсийг хууль тогтоомжид нийцүүлэн тогтоон, олгох;
- 3.1.3 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг гэрээний дагуу ажиллахыг шаардах;
- 3.1.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн гэрээний заалт биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах.

3.2 Байгууллага нь дараах үүрэгтэй:

- 3.2.1 Энэхүү журмын 2.2, 2.8-д заасан баримт бичгүүдийг журамд заасан хугацаанд үнэн зөв бүрдүүлж, ажлын албанд хүргүүлэх;
- 3.2.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажиллах;
- 3.2.3 Зөвшөөрөл олгосон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн эмнэлгийн тусламж үйлчилгээг монгол хэлээр үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх, энэхүү журмын 3.4-т заасан шалгуурыг хангасан орчуулагч ажиллуулах;
- 3.2.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй хийсэн гэрээгээ цуцалсан тохиолдолд ажлын 5 хоногийн дотор ажлын алба, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжид албан тоотоор тус тус мэдэгдэх;
- 3.2.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтнийг ажиллуулсан тухай тайлан, тухайн мэргэжилтэнтэй хийсэн гэрээний хуулбарыг гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн хугацаа дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ажлын албанд хүргүүлэх;
- 3.2.6 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаатай холбоотой хүний эрүүл мэндэд хохирол учирсан болон бусад зөрчил, сөрөг үр дагавар гарсан тохиолдолд хуулийн хариуцлага бүрэн хүлээх.

3.3 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй байгуулах гэрээнд байгууллага нь дараах нөхцлийг заавал тусгана:

- 3.3.1 Ажиллах хугацаа;
- 3.3.2 Албан тушаал, ажлын газрын хаяг, ажиллах нөхцөл;
- 3.3.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл;
- 3.3.4 Цалин хөлсний хэмжээ, олгох хугацаа болон нийгмийн даатгалын шимтгэл, татварын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцох;

- 3.3.5 Гадаадын эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаатай холбоотой хүний эрүүл мэндэд хохирол учирсан болон бусад зөрчил, сөрөг үр дагавар гарсан тохиолдолд хүлээх хариуцлага.
- 3.4 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнтэй ажиллах орчуулагч нь дараах шаардлагыг хангасан байна:
- 3.4.1 Тухайн гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх гадаад хэлийг дээд түвшинд эзэмшсэнийг гэрчлэх үнэмлэх, баримт бичигтэй байх;
- 3.4.2 Эрүүл мэнд, анагаах ухааны чиглэлээр орчуулга хийж байсан туршлагатай буюу түүнийг гэрчлэх баримт бичигтэй байх (өмнө нь орчуулга хийж байсан эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт гэх мэт).

Дөрөв. Гадаадын эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг


- 4.1 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дараах эрхтэй:
- 4.1.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээ явуулах байр, орчинг бүрдүүлэхийг шаардах;
- 4.1.2 Энэхүү журмын 3.4-т заасан шалгуур хангасан орчуулагчтай ажиллах.
- 4.2 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн дараах үүрэгтэй:
- 4.2.1 Монгол Улсад ажиллах хугацаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг бүрэн сахиж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, био-анагаахын ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах;
- 4.2.2 Зөвхөн тухайн төрөлжсөн мэргэшлээр авсан зөвшөөрлийн хүрээнд зөвлөлөөс тогтоосон хугацаанд гэрээ байгуулсан байгууллагад ажиллах;
- 4.2.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг бичгээр авах;
- 4.2.4 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай үзүүлэх;
- 4.2.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ ажиллаж буй байгууллагын монгол эмнэлгийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

Тав. Зөвшөөрлийг хүчингүй болгох, мэдээлэх


- 5.1 Дараах тохиолдолд гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно:
- 5.1.1 Байгууллагын болон гадаадын эмнэлгийн мэргэжилтний санаачлагаар гэрээг хугацаанаас өмнө цуцалсан;
- 5.1.2 Байгууллага болон гадаадын эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, бусад хууль тогтоомжийг зөрчсөн нь холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 5.1.3 Гадаадын эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил болон мэргэжлийн алдаа гаргасан нь холбогдох байгууллагаар тогтоогдсон.
- 5.2 Ажлын алба нь гадаадын эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэрийн төслийг боловсруулж, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжээр хянуулан, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

5.3 Энэхүү журмын 5.2-т заасан шийдвэрийн төсөл, зөвшөөрлийн гэрчилгээг хүчингүй болгохтой холбоотой асуудлын үнэн зөв байдлыг ажлын алба бүрэн хариуцна.



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
98 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт



МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ
ГАРГАХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

Эмнэлгийн мэргэжилтний товч танилцуулга

1. Эцэг (эхийн) нэр _____

2. Өөрийн нэр _____

3. Хүйс (сонгож чагтлах) эмэгтэй эрэгтэй

4. Төрсөн он сар өдөр

5. Аймаг, хот _____

6. Сум, дүүрэг _____

7. Байгууллага: Нэр _____

улсын хувийн (сонгож чагтлах)

8. Албан тушаал (сонгож чагтлах)

- Хүний их эмч
- Нүүр амны их эмч
- Уламжлалт анагаахын их эмч
- Эм зүйч
- Сувилагч
- Хүний бага эмч
- Эх баригч
- Эм найруулагч

9. Регистрийн дугаар


10. Шуудангийн хаяг _____
И-мэйл хаяг _____

11. Утасны дугаар

Ажлын утас	<input type="text"/>
Гар утас	<input type="text"/>
Гэрийн утас	<input type="text"/>

3x4
хэмжээтэй
зураг

Боловсрол, хөдөлмөр эрхлэлт



12. Төгссөн сургууль (ерөнхий боловсролын сургууль, анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг бичнэ)

Сургууль	Орсон он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом/гэрчилгээний дугаар

13. Мэргэжлийн зэрэг

Зэрэг	Авсан огноо	Үнэмлэхний дугаар

14. Боловсролын зэрэг

Хаана	Огноо	Сэдэв	Боловсролын болон эрдмийн цол, зэрэг	Үнэмлэхний дугаар

15. Мэргэшлийн бэлтгэл

(Ажил, мэргэжил, бусад чиглэлээр суралцаж, мэргэшсэн байдлыг бичнэ)

Хаана	Эхэлсэн он, сар	Дууссан он сар	Мэргэшлийн чиглэл	Гэрчилгээ/үнэмлэхний дугаар

16. Ажилласан туршлага

Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон он	Ажлаас гарсан он

Зөвшөөрөл олгох хүсэлт

17. Зөвшөөрлийн төрөл (зурах) /эмчлэх, сувилах, эх барих, эм барих/

18. Хүсэлт гаргасан удаа (зурах) /анх удаа, давтан/


19. Хэрэв зөвшөөрөл давтан авч байгаа бол шалтгаан (сонгож чагтлах)

- Эрүүл мэндийн тухай хуулийн 26.3-д заасны дагуу;
- Эрүүгийн хуулийн 101.1, 102.1, 104.2, 105.1, 106.1-д заасны дагуу;
- Зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд багц цаг биелүүлээгүй бөгөөд дараа зөвшөөрлийн шалгалтанд ороогүй буюу тэнцээгүй;
- Нэг жилээс дээш хугацаагаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлээгүй;
- Гэмтээсэн, үрэгдүүлсэн.

Хүсэлт гаргасан огноо

он сар өдөр

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
98 дугаар тушаалын 4 дүгээр
хавсралт



ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ МЭРГЭШҮҮЛЭХ
БОЛОН ДАВТАН СУРГАЛТЫН БАГЦ ЦАГ БҮРТГЭХ ДЭВТРИЙН ЗАГВАР

Ерөнхий мэдээлэл

1. Эцэг (эхийн) нэр _____

2. Өөрийн нэр _____

3. Хүйс (сонгож чагтлах) эмэгтэй эрэгтэй

4. Төрсөн он сар өдөр

5. Гэрийн хаяг
Аймаг, хот _____
Сум, дүүрэг _____

6. Шуудангийн хаяг _____

7. И-мэйл хаяг _____

8. Утасны дугаар: Ажлын утас
Гэрийн утас
Гар утас

9. Байгууллага: улсын хувийн (сонгож чагтлах)

10. Ажлын хаяг: _____

Аймаг, хот _____


Сум, дүүрэг _____

11. Албан тушаал: _____

3x4
хэмжээтэй
зураг

12. Төгссөн сургууль (ерөнхий боловсролын сургууль, анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж, төгсөлтийн дараах сургалтыг бичнэ)

Сургууль	Орсон он	Төгссөн он	Эзэмшсэн мэргэжил	Диплом/гэрчилгээний дугаар



13. Ажилласан туршлага

Байгууллага	Албан тушаал	Ажилд орсон он	Ажлаас гарсан он

14. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн талаарх мэдээлэл


Зөвшөөрлийн төрөл	Гэрчилгээний дугаар	Олгосон огноо	Дуусах огноо	Тайлбар

15. Багц цагийн бүртгэл

№	Багц цаг бүрдүүлсэн хэлбэр						Огноо	Хянасан
	Албан сургалт	цаг	Албан бус сургалт	цаг	Судалгаа шинжилгээний ажил, бүтээл, практикт нэвтрүүлсэн шинэ санаачилга	цаг		

---oOo---

Эрүүл мэнд, спортын сайдын
 2015 оны 03 сарын 16 өдрийн
 98 дугаар тушаалын 5 дугаар
 хавсралт



**ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ТӨГСӨЛТИЙН ДАРААХ МЭРГЭШҮҮЛЭХ БОЛОН
 ДАВТАН СУРГАЛТЫН БАГЦ ЦАГ БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ,
 БАГЦ ЦАГ БҮРДҮҮЛСЭН ХЭЛБЭРИЙГ БҮРТГЭХ КОД**

1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг биелүүлсэн эмнэлгийн
 мэргэжилтний жагсаалт


Байгууллагын нэр:.....

№	Овог, нэр	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн дугаар	Олгосон огноо	Багц цаг бүрдүүлсэн хэлбэр				Нийт багц цаг		
					Албан сургалт	Албан бус сургалт	Судалгаа шинжилгээний ажил, бүтээл, практикт нэвтрүүлсэн шинэ санаачилга	Бус			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

БАТАЛГААЖУУЛСАН
 (Байгууллагын дарга)

 (гарын үсэг)

2. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын багц цаг биелүүлээгүй эмнэлгийн мэргэжилтний жагсаалт




Байгууллагын нэр:.....

№ Овог, нэр	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн дугаар	Олгосон огноо	Багц цаг бүрдүүлсэн хэлбэр					Дутуу багц цаг		
				Албан сургалт	Албан бус сургалт	᠘᠙᠓	᠘᠙᠓	Судалгаа шинжилгээний ажил, бүтээл, практикт нэвтрүүлсэн шинэ санаачилга			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

БАТАЛГААЖУУЛСАН
(Байгууллагын дарга)
.....
(гарын үсэг)

3. Багц цаг бүрдүүлсэн хэлбэрийг бүртгэх код

Доорх кодыг ашиглан багц цагийн баталгаажуулалтын хүснэгтийн 6, 8, 10, 12 дах баганад тохирох кодыг, 7, 9, 11, 13 дах баганад харгалзах багц цагийг оруулан бүртгэнэ.



A. Албан сургалт (багана 6)

- A 1. Үндсэн мэргэшлийн сургалтанд суралцах
- A 2. Мэргэжил олгох сургалтанд суралцах
- A 3. Мэргэжил дээшлүүлэх сургалтанд суралцах
- A 4. Анагаах ухааны магистрын сургалтанд суралцах
- A 5. Анагаах ухааны докторын сургалтанд суралцах

АБ. Албан бус сургалт (багана 8)

- АБ 1. Мэргэжлийн чиглэлээр семинарт оролцох
 - АБ 1.1 Олон улсын хэмжээнд
 - АБ 1.2 Улсын хэмжээнд
 - АБ 1.3 Орон нутгийн хэмжээнд
- АБ 2. Мэргэжлийн төрөлжсөн зөвлөгөөн, хуралд илтгэл тавих
 - АБ 2.1 Олон улсын хэмжээнд
 - АБ 2.2 Улсын хэмжээнд
 - АБ 2.3 Орон нутгийн хэмжээнд
- АБ 3. Эмгэг судлалын конференцид оролцох
- АБ 4. Мэргэжлийн чиглэлээр зайны сургалтанд суралцах
- АБ 5. Мэргэжлийн чиглэлээр ажлын байрны болон сэдэвчилсэн сургалтанд суралцах
- АБ 6. Мэргэжлийн зэрэг хамгаалах

С. Судалгааны ажил, бүтээл (багана 10)

- С 1. Илтгэл тавих
 - С 1.1 Байгууллагын хэмжээнд
 - С 1.2 Их, дээд сургуулийн хэмжээнд
 - С 1.3 Улс, олон улсын хэмжээнд
- С 2. Оношлогоо, эмчилгээний стандарт боловсруулахад оролцох
- С 3. Судалгааны ажил удирдах
- С 4. Судалгааны багт оролцох
- С 5. Төсөл, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт ажиллах
- С 6. Мэргэжлийн зөвлөмж боловсруулж хэвлүүлэх
- С 7. Гарын авлага, аргачлал боловсруулж хэвлүүлэх
- С 8. Мэргэжлийн ном туурвих
- С 9. Мэргэжлийн ном туурвихад оролцох, шүүмж, дүгнэлт гаргах, хянах
- С 10. Мэргэжлийн ном орчуулах
- С 11. Мэргэжлийн ном орчуулахад хамтрах
- С 12. Шинэ бүтээл, тэргүүн туршлага гаргаж, баталгаажуулсан байх
- С 13. Мэргэжлийн сургалтанд хичээл заах
- С 14. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хийх
- С 15. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ арга, технологи нэвтрүүлэх

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
98 дугаар тушаалын 6 дугаар
хавсралт

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1-д заасан хугацаагаар хүний их эмчид олгох “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар шаргал дэвсгэртэй, тод шаргал угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Хүний их эмч овогтой-д

Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаатай олгов.


САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан хүний их эмчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

2. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.2-д заасан хугацаагаар хүний их эмч, нүүр амны их эмч, уламжлалт анагаахын их эмчид олгох “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар ногоон дэвсгэртэй, тод ногоон угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.



Хүний их эмч, нүүр амны их эмч, уламжлалт анагаахын их эмч (аль нэгийг бичих)

..... овогтой-д

Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг оны сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.


САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан их эмчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

3. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.2-д заасан хугацаагаар хүний бага эмчид олгох “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар ногоон дэвсгэртэй, тод ногоон угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.



Хүний бага эмч овогтой-д


Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг оны сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан хүний бага эмчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

4. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.3-д заасан хугацаагаар эм зүйчид олгох “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:



- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар шаргал дэвсгэртэй, гадуураа улбар шар өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Эм зүйч овогтой-д

Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар ЭМ БАРИХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эм зүйчийн 3х4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

5. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.3-д заасан хугацаагаар эм найруулагчид олгох “Эм барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар шаргал дэвсгэртэй, гадуураа улбар шар өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Эм найруулагч овогтой-д

Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар ЭМ БАРИХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.


САЙД

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эм найруулагчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

6. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.4-д заасан хугацаагаар сувилагчид олгох “Сувилах” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар цэнхэр дэвсгэртэй, хөх өнгийн угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.



Сувилагч овогтой-д


Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар СУВИЛАХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан сувилагчийн 3x4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

7. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.5-д заасан хугацаагаар эх баригчид олгох “Эх барих” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:



- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар бор шаргал дэвсгэртэй, гадуураа тод бор шаргал өнгийн угалзан хээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

Эх баригч овогтой-д


Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар ЭХ БАРИХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг онысарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан эх баригчийн 3х4 см хэмжээтэй зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
98 дугаар тушаалын 7 дугаар
хавсралт



ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

1. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.4-д заасан хугацаагаар гадаадын хүний их эмчид олгох “Эмчлэх” үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:

- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар ягаан дэвсгэртэй, ягаан өнгийн угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж “Монгол Улс”, “Эрүүл мэнд, спортын яам”, түүний доод хэсэгт “Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ГЭРЧИЛГЭЭ” гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

..... улсын харьяат

.....-д


Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар төрөлжсөн мэргэшлээр ЭМЧЛЭХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг оны сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл хугацаатай олгов.

САЙД.....

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан их эмчийн 3x4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна.

2. Эрүүл мэндийн тухай хуулийн 25.4-д заасан хугацаагаар гадаадын сувилагчид олгох "Сувилах" үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ нь дараах бичлэгтэй байна:



- Гэрчилгээ нь 210 мм х 297 мм хэмжээтэй байна.
- Гэрчилгээ нь цайвар ягаан дэвсгэртэй, ягаан өнгийн угалзан хээн хүрээтэй байна.
- Гэрчилгээний дээд хэсэгт соёмбо байрлуулж "Монгол Улс", "Эрүүл мэнд, спортын яам", түүний доод хэсэгт "Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ" гэж бичсэн байна.
- Гэрчилгээ нь нууцлалтай байна.
- Гэрчилгээ нь дараах байдлаар бичигдэнэ.

..... улсын харьяат

.....-д


Эрүүл мэнд, спортын сайдын оны сарын өдрийн дугаар тушаалаар төрөлжсөн мэргэшлээр СУВИЛАХ үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг оны сарын-ны өдрөөс оны сарын-ны өдөр хүртэл хугацаатай олгов.

САЙД

..... он сар өдөр

- Гэрчилгээ нь серийн дугаартай байна.
- Гэрчилгээний зүүн доод хэсэгт зөвшөөрөл авсан сувилагчийн 3х4 см зураг байрлуулна.
- Гэрчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж албажуулна

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
98 дугаар тушаалын 8 дугаар
хавсралт




ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ТАНИЛЦУУЛГЫН МАЯГТ

Байгууллагын мэдээлэл

1. Урьж буй байгууллагын нэр
2. Урьж буй байгууллагын хаяг
3. Урьж буй байгууллагын холбоо барих утас, хариуцах хүн/эмнэлгийн мэргэжилтний нэр

Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэдээлэл


1. Овог нэр
2. Нас
3. Хүйс
4. Яс үндэс
5. Үндсэн захиргаа
6. Паспортын дугаар, хүчинтэй байх хугацаа
7. Монгол Улсад зорчихоор мэдүүлсэн визийн ангилал, төрөл
8. Боловсролын зэрэг
9. Төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зэрэг
10. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний дугаар, олгосон огноо, хүчинтэй хугацаа
11. Урьд эрхэлж байсан ажил (он дарааллаар):
12. Одоо эрхэлж байгаа ажил, албан тушаал:
13. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн төрөл
14. Үзүүлэх гэж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэл (дэлгэрэнгүй бичнэ, мэс заслын нэр, төрөл гэх мэт), үндэслэл



Урьж буй байгууллагын дарга /нэр/

Гарын үсэг, тамга, тэмдэг

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
98 дугаар тушаалын 9 дүгээр
хавсралт



**ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТЫН КОМИССЫН ГИШҮҮНЭЭР АЖИЛЛАХЫГ
ЗӨВШӨӨРСӨН МЭДҮҮЛГИЙН МАЯГТ**

/ Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд томилогдсон гишүүдэд хамаарна/

..... албан тушаалтай овогтой
..... би

/ Шалгалтын комиссын гишүүн нэр, албан тушаалаа бичнэ/

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга/захирлын оны дугаар тушаалаар шалгалтын комиссын гишүүнээр томилогдон ажиллахыг зөвшөөрч, энэхүү мэдэгдлээр дараах баталгааг гаргаж байна:

Нэг.

1.1 Тухайн шалгалтанд орох эмнэлгийн мэргэжилтнүүдтэй сонирхлын зөрчилгүй байна. Хэрэв сонирхлын зөрчил бий болох нөхцөл үүссэн тохиолдолд шударгаар мэдэгдэж комиссын гишүүнээс татгалзана.

1.2 Шалгалт авах үйл ажиллагаанд хувийн сонирхлоор бус, хөндлөнгийн байр сууринаас хандана.

1.3 Миний хараат бус, хөндлөнгийн байр сууринаас хандах байдалд нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал байхгүй болно.

Хоёр.

Шалгалтын бэлтгэл ажил болон шалгалт авах үйл ажиллагааг Монгол Улсын Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хэм хэмжээг баримтлан, заагдсан эрх үүргийн дагуу шударга гүйцэтгэнэ.

Гарын үсэг.....

Огноо.....

Албан ажлын хэрэгцээнд:

	Овог нэр	Албан тушаал	Гарын үсэг	Огноо	Цаг, минут
Хүлээн авсан					